

2007 оны 2-р сар

## 2007-02-09. “Уул уурхайн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо” сэдэвт сургалт –семинар боллоо

Азийн Хөгжлийн Банкны санхүүгийн тусламжтайгаар хэрэгжүүлж буй “Монголын уул уурхайн салбар дахь авилгалын асуудалд олон нийтийн хяналт-шинжилгээ” сэдэвт төслийн хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар, “Хүний эрх ба хөгжил төв”, “Хөвсгөл далайн эзэд”, “Онон-Улз”



болон “Иргэний боловсрол төв” зэрэг төрийн бус байгууллагатай хамтран **“Уул уурхайн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо”** сэдэвт сургалт - семинарыг 2007 оны 2 дугаар сарын 4-8 ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион явууллаа.

Уг сургалт-семинарт дээр дурьдсан болон Хөвсгөл, Сэлэнгэ, Хэнтий аймгийн иргэний нийгмийн байгууллагын 30 гаруй төлөөлөгчдийг оролцуулан Монгол

Улсад батлагдаад удаагүй байгаа ашигт малтмал болон авилгалын эсрэг хуулийг орон нутагт сурталчлах, эдгээр хуулийг хэрэгжих явцад гарч болох зөрчил, авилгал түүний нөхцөл шалтгаан зэргийн талаар хобогдох мэргэжилтнүүдээр сургалт явуулсан бөгөөд зарим улс орны туршлага мэдээллийн талаар харилцан ярилцлаа. Ашигт малтмалын хууль болон авилгалын хуулийн асуудлаар уг хуулийг боловсруулсан ажлын хэсгийн хүмүүс тухайлбал Улсын Их Хурлын гишүүн Ц. Дамиран, ҮХЯ-ны геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга Ц.Даваадорж нар хуулийн үзэл баримтлал агуулгын талаар тодорхой ярилцсан бол холбогдох сэдвээр Барилга хот байгуулалтын яамны Газрын харилцаа, эрхийн бүртгэлийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мөнхбаатар болон зөвлөх Д.Ламжав, БОЯ-ны холбогдох асуудлын



хариуцсан түшмэдүүд мөн уул уурхайн салбар дахь зөрчил дутагдлын талаар Улсын мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын албаны дарга Б.Саран зэрэг мэргэжлийн хүмүүсээр хичээл заалгасан нь зохих үр дүнгээ өгсөн байна. Мөн Кадастрын зураг дээр ажиллах, лицензийн тухай, бүртгэл түүний хяналт тавих талаар Монгол Улсын Их сургуулийн зайнаас тандан судлах газарзүйн мэдээллийн системийн лабораторид дадлагын ажил хийсэн нь чухал ач холбогдолтой болсон.

Цаашид сургалтад оролцсон эдгээр хүмүүс нутагдаа очоод ашигт малтмалын болон авилгалын хуулийг сурталчлах, ашигт малтмал хайгуул, олборлох үйл ажиллагаан дахь авилгал гарах нөхцөл түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бидэнтэй хамтран ажиллах юм.

**Бэлтгэсэн:**

Долгормаа, [dolgormaa@wwf.mn](mailto:dolgormaa@wwf.mn)  
Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн  
Монгол дахь Хөтөлбөрийн газар